



Үндэсний аудитын газрын харьяа
Хэнтий аймгийн аудитын газар

УАГ-НАГ-/2016/03/НА-ХЭ
АУДИТЫН НЭР:ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ
САНГИЙН ҮЙП АЖИППАГАНДЫ УР ЛҮН

**СУМДЫН БАЙГАЛЬ ХАМГААЛАХ САНГИЙН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН
ОРЧИН БҮРДЭЭГҮЙ БАЙНА.**



9/20/2016

АГУУЛГА

Тайлан бэлтгэсэн Хэнтий аймгийн Аудитын газар Тэргүүлэх аудитор: Ц.Энхтүвшин Аудитын менежер: Б.Наранцэцэг Аудитор: Ү.Төгсжаргал, Ц.Нарангэрэл 2016 оны 10 дугаар сар Аудитын тайлан дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал аймгийн Аудитын газрын 7056-2147 тоот утсаар харилцана уу. Хаяг Хэнтий аймгийн Аудитын газар. Аймгийн ЗДТГ-ын байр. 315 тоот өрөө	Агуулга	
	Товчилсон үгийн тайлбар	
	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	
	Ерөнхий мэдээлэл	
	Нэгдүгээр бүлэг: Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний эрх зүйн орчин бүрдсэн боловч байгаль хамгаалах сангийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин бүрдээгүй байна.	
	Хоёрдугаар бүлэг: Сумдын байгаль хамгаалах санд зарим орлогыг хууль зөрчин төвлөрүүлсэн байна.	
	Гуравдугаар бүлэг: Аймгийн ИТХ-аар байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг нэмэгдүүлэн баталдаг боловч зардлыг нэмэгдүүлж батлахгүй байна.	
	Дөрөвдүгээр бүлэг: Байгаль хамгаалах санд тавих дотоод хяналтын тогтолцоо бүрдээгүй байна.	
	Аудитын дүгнэлт	
	Аудитын зөвлөмж	
	Үндэсний Аудитын газарт хүргүүлэх санал	
	Аудитын тайлангийн төсөлд ирүүлсэн холбогдох байгууллагын санал	
	Холбогдох байгууллагаас ирүүлсэн саналд өгөх тайлбар	
	Аудитаар илэрсэн зөрчил ба акт, албан шаардлагын жагсаалт	
	Аудитын тайлангийн баталгаажуулалт	

[illegible]

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ**Нэг: Аудит хийх үндэслэл, бүрэн эрх**

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2016 оны 1-дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудитортай аймгийн Тэргүүлэх аудиторын 2016 онд байгуулсан үр дүнгийн гэрээ, Хэнтий аймгийн Аудитын газрын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн “Төрийн аудитын тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2014 оны 121 дүгээр тушаалаар батлагдсан “Нийслэлийн болон аймгийн Аудитын газрын дарга Тэргүүлэх аудиторт зөвшөөрөх бүрэн эрх”-ийн хүрээнд аудитыг хийж гүйцэтгэлээ.

Хоёр: Аудитын зорилт

“Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн”-д хийж буй нийцлийн аудитын хүрээнд Хэнтий аймгийн БОАЖГ-ын байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ, сумдын байгаль хамгаалах сангийн үйл ажиллагаанд хууль тогтоомж нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актаар тогтоосон шаардлагыг сахин биелүүлж байгаа байдлыг шалгаж дүгнэлт, зөвлөмж гарган аудитын дүнг аймгийн ИТХ-д танилцуулж, аудитын тайланг ҮАГ-д хүргүүлэхэд аудитын зорилго оршино.

Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэлээ. Үүнд:

- Хууль эрх зүйн зохицуулалт нь үйл ажиллагааг бүрэн хангаж байгаа эсэх
- Сангийн хөрөнгийг хуульд заасны дагуу төлөвлөж бүрэн бүрдүүлж байгаа эсэх
- Сангийн хөрөнгийг хууль тогтоомжид заасны дагуу зарцуулж үр дүн гарч байгаа эсэх
- Дотоод хяналт үр нөлөөтэй хэрэгжиж байгаа эсэх
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Гурав: Аудитын хамарсан хүрээ

Аудитад БОАЖГ-ын байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ, нийт 16 сумын байгаль хамгаалах сангийн 13 буюу 81.2 хувийн 2015, 2016 оны эхний хагас жилийн төлөвлөгөө, гүйцэтгэсэн ажлын тайлан, санхүүгийн баримт материалыг хамруулсан.

Дөрөв: Аудитын арга зүй, стандартын талаарх мэдээлэл

Аудитыг АДБОУС 100-400, 4200, нийцлийн аудитын гарын авлагыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа болон судалгаа авч, аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүн шинжилгээ хийн аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулж ажиллалаа.

Тав: Аудит хийсэн хугацаа:

Аудитад шаардлагатай мэдээлэл цуглуулах ажлыг 2015 оны 8 дугаар сарын 15-наас 8 дугаар сарын 22-ны хооронд хийж, цуглуулсан мэдээллийг нотлох дүн шинжилгээ хийх ажлыг 9 дугаар сарын 05-наас 9 дугаар сарын 23-ны хооронд, тайлагнах үе шатны ажлыг 9 дугаар сарын 26-наас 10 дугаар сарын 10-ны хооронд хийж холбогдох байгууллагаас саналыг авч, аудитын

дүн, тайланг аймгийн Аудитын газрын Удирдлагын зөвлөлд 2016 оны 10 дугаар сарын 11-нд аудитор Ү.Төгсжаргал танилцуулав.

Долоо: Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитыг аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ц.Энхтүвшин хянана удирдаж, аудитын менежер Б.Наранцэцэг стандартыг хангуулж, аудитор Ү.Төгсжаргал, Ц.Нарангэрэл нар хийж гүйцэтгэлээ.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Засгийн газрын байгаль хамгаалах сангаас Хэнтий аймагт хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ байхгүй боловч орон нутагт байгаль хамгаалах чиглэлээр хийгдсэн ажлыг аудитад хамруулсан болно.

Аймгийн ИТХ-ын 2014 оны 12 сарын 03-ны өдрийн 01 тоот тогтоолоор 2015 онд Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 329.5 сая төгрөгийн төсөв батлагдаж 235.3 сая төгрөгөөр 23 төрлийн 41 ажлуудыг хийж, жилийн эцэст зарцуулагдаагүй үлдэгдэл 101.1 сая төгрөгийг орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлсэн байна.

Мөн аймгийн ИТХ-ын 2015 оны 12 сарын 03-ны 03 тоот тогтоолоор 2016 онд 266.9 сая төгрөгийн төсөв батлагдаж 2016 оны эхний хагас жилд 11 төрлийн 34 ажлыг 126.8 сая төгрөгөөр хийж зарцуулсан байна.

Сангийн сайдын 2015 оны 4-1/4198, 4-1/6795 тоот албан бичгүүдээр Төсвийн тухай хуулиар зөвшөөрөгдөөгүй орон нутгийн тусгай санг татан буулгах тухай чиглэл өгөгдсөн байна. Гэвч сумын байгаль хамгаалах сангууд татан буугдаагүй одоог хүртэл үйл ажиллагааг явуулж байна.

Сумдын байгаль хамгаалах сангийн үйл ажиллагаа, 2015, 2016 оны эхний хагас жилийн орлого зарлагын гүйцэтгэлийг Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр, Баян-Адрага, Норовлин, Дадал, Батноров, Дархан, Дэлгэрхаан, Цэнхэрмандал, Бор-Өндөр, Жаргалтхаан, Галшар сумдад очиж шалгалаа

Сумдын байгаль хамгаалах санд 2015 оны эхэнд 72.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй, 114.3 сая төгрөгийн орлоготой, 106.5 сая төгрөгийн зардал гаргаж оны эцэст 80.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй ажилласан бөгөөд 2016 оны эхний хагас жилд 12.9 сая төгрөгийн орлоготой, 14.8 сая төгрөгийн зардал гаргаж 78.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй ажилласан байна.

Байгаль хамгаалах сангийн зарцуулалтын гүйлгээнд 1 дүгээр гарын үсгийг дээрх сумын Засаг дарга, 2 дугаар гарын үсгийг сумын ЗДТГ-ын нягтлан бодогч нар зурж гүйлгээг хийж, хөрөнгө мөнгийг захиран зарцуулж байна.

1.1. Сумын байгаль хамгаалах санг зохицуулсан эрх зүйн акт байхгүй байна.

1.1а 2015 оноос эхлэн аймгийн БОАЖГ-ын байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг төлөвлөн баталж “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай” хуулиар зохицуулагдаж байна. Зарцуулалтыг Засгийн газрын 2014 оны “Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх зарцуулах тайлагнах журам”-аар зохицуулж байна.

1.1б Аудитад хамрагдсан 5 сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор “Байгаль хамгаалах сангийн журам-ыг баталсан байхад бусад суманд байгаль хамгаалах сангийн үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн акт байхгүй байна.

Сумын байгаль хамгаалах сан нь Засгийн газрын тусгай сангийн хуулиар зохицуулагддаггүй байна.

1.2 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээг зохицуулах эрх зүйн орчин бүрдсэн боловч сумын байгаль хамгаалах сангийн үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн орчин бүрдээгүй байна.

1.2а Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай” хууль, Засгийн газрын 2014 оны “Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх зарцуулах тайлагнах журам”-ыг аймгийн БОАЖГ хэрэгжүүлэн байгаа байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулж байна.

1.2б Хэдийгээр 5 суманд байгаль хамгаалах сангийн журмыг ИТХ-аар баталсан боловч тухайн журам хэрэгжих нөхцөл бүрдээгүй байна. Энэ нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17.1.1 дэх заалтыг хэрэгжүүлдэггүй холбоотой.

1.3 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал нь Төсвийн болон Байгаль орчныг хамгаалах тухай хуультай нийцэж байхад сумын байгаль хамгаалах сан нь Төсвийн тухай хуультай нийцэхгүй байна.

1.3а Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай” хууль, Засгийн газрын 2014 оны “Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх зарцуулах тайлагнах журам нь Төсвийн тухай болон Байгаль орчныг хамгаалах тухай хуультай нийцэж байна.

1.3б Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлд сумын ИТХ Засаг даргын бүрэн эрхийн хүрээнд төсөв мөнгө шаардсан ажлуудыг хэрэгжүүлэхээр заасан боловч сумын байгаль хамгаалах сан байгуулах нь Төсвийн тухай хуулийн 18.4 дэхь заалттай зөрчилдөж байна.

2.1 Байгаль нөөц ашигласны төлбөрийн орлогыг Сангийн яамны хянасан дүнгээс аймгийн ИТХ нэмэгдүүлэн баталж байна.

2.1а Санхүү төрийн сангийн хэлтэс нь БОАЖГ-аас ирүүлсэн саналыг хянаж, Сангийн яаманд хүргүүлж, дараа оны орлого, зарлагын төлөвлөгөөг батлуулж байна.Үүнд

БОАЖГ нь 2015 онд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөний саналыг холбогдох хууль тогтоомжоор тогтоосон хувь хэмжээ, нотлох баримтыг үндэслэн боловсруулан тооцож, аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэст 1044.3 сая төгрөгөөр хүргүүлсэн боловч 841.4 сая төгрөгөөр бууруулан Сангийн яаманд хянуулжээ.

2015 оны Сангийн Яамны хянасан орлогын дүнг аймгийн ИТХ-аар тодотгон баталсан орлогын дүнтэй харьцуулахад ойн нөөц ашигласны орлогыг 133.3 сая төгрөгөөр, ангийн орлогыг 216.1 сая төгрөгөөр, ус, рашаан ашигласны орлогыг 104.4 сая төгрөгөөр нийт 458.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, 1299.9 сая төгрөгөөр баталсан байна.

2015 оны Сангийн яамны хянасан, аймгийн ИТХ-аар баталсан орлогын судалгаа

сая.төг

д/д	Орлогын төрөл	БОАЖГ-ын санал	СЯ-ны хянасан	Аймгийн ИТХ-ын баталсан	Аймгийн ИТХ-ын тодотгосон	Гүйцэтгэл
1	Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого	364.3	166.0	354.8	299.3	252.6
2	Ус рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого	534.4	529.2	638.8	638.8	408.0
3	Амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого	39.5	40.0	64.9	255.6	269.8
4	Газрын төлбөр	106.2	106.2	106.2	106.2	166.3
	Бүгд	1044.3	841.4	1164.7	1299.9	1096.8

БОАЖГазар нь 2016 онд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөний саналыг мөн холбогдох хууль тогтоомжоор тогтоосон хувь хэмжээ, нотлох баримтыг үндэслэн боловсруулан тооцож, аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэст 990.4 сая төгрөгөөр хүргүүлсэн боловч байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг 573.6 сая төгрөг буюу 416.8 сая төгрөгөөр бууруулан Сангийн яаманд хянуулжээ.

2016 оны Сангийн Яамны хянасан орлогын дүнг аймгийн ИТХ-ын баталсан орлогын дүнтэй харьцуулахад ойн нөөц ашигласны орлогыг 62.7 сая төгрөгөөр, ангийн орлогыг 122.3 сая төгрөгөөр, ус рашаан ашигласны орлогыг 656.5 мянган төгрөгөөр, газрын төлбөрийн орлогыг 29.5 сая төгрөгөөр нийт 871.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн , 1444.6 сая төгрөгөөр баталсан байна.

2016 оны Сангийн яамны хянасан, аймгийн ИТХ-аар баталсан орлогын судалгаа

сая.төг

д/д	Орлогын төрөл	БОАЖГ-ын санал	СЯ-ны хянасан	Аймгийн ИТХ-ын баталсан	2016 оны ХБГүйцэтгэл
1	Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого	238.3	174.5	237.2	238.3
2	Ус рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого	423.2	223.4	879.9	844.3
3	Амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого	203.7	43.2	165.5	100.4
4	Газрын төлбөр	125.2	132.5	162.0	129.4
	Бүгд	990.4	573.6	1444.6	1312.4

Эндээс үзэхэд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг аймгийн ИТХ 2015 онд 24 хувиар, 2016 он 45 хувиар тус тус нэмэгдүүлсэн нь БОАЖГ саналыг үндэслэлтэй төлөвлөж хүргүүлсэн байна гэж үзлээ.

Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс мэргэжлийн байгууллагаас хүргүүлсэн саналыг үндэслэлгүйгээр бууруулан Сангийн яаманд хүргүүлсэн нь улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг нэмэгдүүлэх нөхцөл бүрдүүлж байна.

2.16 Сумын байгаль хамгаалах сангийн орлого, зарлагын төлөвлөгөөг 2015 онд нийт сумд хийж батлуулдаггүй байсан бол 2016 оноос эхлэн аймгийн Төрийн сангаас өгсөн чиглэлийн дагуу ихэнх сумд ИТХ-аар батлуулсан байна.

2.2 Сумдын байгаль хамгаалах санд зарим орлогыг хууль зөрчин төвлөрүүлсэн байна.

2.2а Байгаль нөөц ашигласны төлбөрийн орлогын бүрдүүлэлтийг байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитаар шалгасан тул энэхүү тайланд тусгасангүй.

2.2б. Сумдын байгаль хамгаалах санд 2015 онд нөхөн сэргээлтийн барьцаанд 32.5 сая төгрөг, загасны төлбөр хураамж, идлэг шонхор шувууны төлбөр хураамж, нохойны татвар 25.3 сая төгрөг, хохирлын төлбөр гарал үүслийн төлбөрт 21.3 сая төгрөг, үнэт цаасны орлогод 1.4 сая төгрөг, торгуулийн орлогод 6.0 сая төгрөг, хандивын орлогод 1.2 сая төгрөг, нэр данс зөрүүтэй гүйлгээ 26.4 сая төгрөг байна. Орлогын задаргааг Хавсралт №01 хавсаргав.

Сумдын байгаль хамгаалах санд төвлөрүүлсэн ангийн болон нохойн нийт 25.3 сая төгрөгийн орлогоос орон нутгийн төсвийн орлогод 6.1 сая төгрөгийг төвлөрүүлж, үлдсэн 19.2 сая төгрөгийг төвлөрүүлэлгүйгээр зарцуулж, холбогдох хуулийн заалтыг зөрчсөн байна. Үүнд:

Биндэр сумын Засаг дарга нь 6.0 сая төгрөгийн загасны төлбөр, Дадал сумын Засаг дарга нь 0.1 сая төгрөгийн загасны төлбөр, Дэлгэрхаан сумын Засаг дарга нь 6.4 сая төгрөгийн шонхорын орлого, Норовлин сум Засаг дарга нь 6.2 сая төгрөгийн чоно, цагаан зээрийн төлбөр, Баян-адрага сумын Засаг дарга нь 0.5 сая төгрөгийн нохойны татварыг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй, Төсвийн тухай хуулийн 23.8.4, 23.8.11 дахь заалтыг тус тус зөрчсөн байна

3.1 Аймгийн ИТХ-аар байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг нэмэгдүүлэн баталдаг боловч зардлыг нэмэгдүүлж батлахгүй байна.

3.1а Хэнтий аймгийн 2015 оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг Сангийн яам 841.4 сая төгрөгөөр, зардлыг 329.5 сая төгрөгөөр, 2016 онд орлогыг 573.3 сая төгрөгөөр зардлыг 266.9 сая төгрөгөөр тус тус хянаж баталсан бөгөөд Сангийн яамны хянасан орлогын дүнг байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1 дахь заалтын дагуу тооцоход 2015 оны зардлыг 32.7 сая төгрөгөөр, 2016 оны зардлыг 1.0 сая төгрөгөөр тус тус бууруулан хянасан байна

2015 оны орлогын гүйцэтгэлийг байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу тооцоход 517.4 сая төгрөг, 2016 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 567.7 сая төгрөг бөгөөд Сангийн яамны хянасан зардлын дүнгээс 2015 онд 187.8 мянган төгрөгөөр, 2016 онд 300.8 сая төгрөгөөр нийт 488.6 сая төгрөгийг дутуу тооцож олгосон байна.

2015 оны орлогын гүйцэтгэлийг Сангийн яамны хянасан зардлын дүнтэй харьцуулсан судалгаа

/сая.төг/

д/д	Орлогын төрөл	2015 оны Орлогын гүйцэтгэл	2015 оны СЯ-ны хянасан зардал	2015 оны Хуулиар байвал зохих	2015 оны зөрүү	Аймгийн ИТХ баталсан зардал
1	Ойн НАТО	252.6	141.1	214.7	-73.6	
2	Ус, рашааны НАТО	408.1	152.7	142.8	+9.9	
3	Амьтны НАТО	269.8	19.7	134.9	-115.1	
4	Газрын төлбөр	166.3	15.9	24.9	-9.0	
	ДҮН	1096.8	329.4	517.4	187.8	329.4

2016 он ХБГ-ийг Сангийн яамны хянасан зардалтай харьцуулсан судалгаа

/ сая.төг/

д/д	Орлогын төрөл	2016 оны ХБГ хянасан	2016 оны Хуваарлигдсан зардал	2016 оны хуулиар байвал зохих	2016 оны зөрүү	Аймгийн ИТХ баталсан зардал
1	Ойн НАТО	238.3	148.3	202.6	-54.3	
2	Ус, рашааны НАТО	844.3	78.2	295.5	-217.3	
3	Амьтны НАТО	100.4	21.6	50.2	-28.6	
4	Газрын төлбөр	129.4	18.8	19.4	-0.6	
	ДҮН	1312.4	266.9	567.7	300.8	266.9

Ийнхүү аймгийн ИТХ-аар байгалийн нөөц ашигласны орлогыг нэмэгдүүлэн баталдаг боловч зардлыг нэмэгдүүлдэггүй, Сангийн яамны хянасан зардлаар байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлыг тооцон олгож байгаа нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13.4, 18.1 дахь заалтуудыг зөрчсөн байна.

3.16 Сумдын 2015 оны байгаль хамгаалах сангийн зардлын гүйцэтгэлийг зардлын төрлөөр нь авч үзвэл нийт 109.3 сая төгрөгийн зардал гаргаж үүнээс шатахууны зардалд 26.1 хувь, суулгац болон ойжуулалтанд 12.7 хувь, урамшууллын зардалд 2.1 хувь, мотоцикль тоног төхөөрөмжид 7.0 хувь, торон хашаа авахад 2.3 хувь, нохой устгал, ойжуулалт болон хог ачилтын ажлын хөлсөнд 5.3 хувь, ойн төлөвлөгөө боловсруулахад 3.1 хувь, булгийн эх хашихад 0.5 хувь, бусад зардалд 5.0 хувийг тус тус зарцуулж, нэр данс зөрүүтэй гүйлгээ 35.3 хувийг тус тус зарцуулсан байна. Зардлын задаргааг Хавсралт №02 хавсаргав.

Дадал сумын Засаг дарга нь 6.5 сая төгрөгийн ойжуулалтын ажил, 0.7 сая төгрөгийн байгаль орчны улсын байцаагчийн хувцас, Өмнөдэлгэр сумын Засаг дарга нь 2.2 сая төгрөгийн байгаль орчны улсын байцаагчид дуран, мотоцикл, GPS, Биндэр сумын Засаг дарга нь 0.4 сая төгрөгийн камер, Баян-адрага сумын Засаг дарга нь 1.4 сая төгрөгийн 5 ширхэг галын үлээгч аппарат, Жаргалтхаан сумын Засаг дарга нь 1,5 сая төгрөгийн мотоцикль худалдан авалт, Баян-Адрага, Биндэр сумын Засаг дарга нь ойн менежментийн төлөвлөгөө хийлгэсэн зэрэг нь үр дүнтэй санаачлагатай ажил болсон байна.

3.2 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлаар хийгдсэн тендерийн ажил нь гэрээний хугацаандаа дуусаагүй байна.

3.2а Байгаль хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр 2015 онд хийгдсэн ажлуудыг шууд гэрээ болон харьцуулалтын аргаар хийсэн байна.

2015 онд БОАЖГ-аас зохион байгуулсан сонгон шалгаруулалтаар Чингис хотын уст цэгийг нэмэгдүүлэх, инженерийн байгууламж байгуулах ажилд Хэнтий-Ус ХХК тендерт шалгарч 40.0 сая төгрөгийн гэрээ байгуулжээ. Хэнтий-Ус ХХК нь худаг гаргах тусгай зөвшөөрөл, цооног өрөмдөх машин механизм байхгүй, тухайн компани өөрөө ашиглагч байгууллага учраас хяналт тавих нөхцөл бүрдээгүй, 2014 оны жилийн эцсийн санхүүгийн аудитын дүгнэлтээр “Дүгнэлт өгөхөөс татгалзсан” 235.7 сая төгрөгийн авлагатай, 364.7 сая төгрөгийн өртэй байхад тендерт шалгаруулсан байна.

БОАЖГ-аас 2015 оны 12 сард Хэнтий-Ус ХХК-д урьдчилгаа санхүүжилт 25.0 сая төгрөгийг шилжүүлсэн байхад одоог хүртэл ажлаа эхлүүлээгүй байгаа нь тендерийн хороо тендерийн ажлыг хангалтгүй зохион байгуулсан, инженерийн хийцтэй худаг гаргадаг тоног төхөөрөмж бүхий мэргэжлийн байгууллагыг сонгож шалгаруулаагүйтэй холбоотой байна.

3.2б Сумдын байгаль хамгаалах сангаас хийгдсэн ажил гүйлгээнд ямар нэгэн хэлбэрээр сонгон шалгаруулалт хийгдээгүй байна.

3.3 2015 оны байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаар хийгдсэн Хэнтий-Ус ХХК-ийн тендерт шалгарсан ажил нь гэрээний хугацааг мөрдөж ажиллаагүй байна.

3.3 а Хэнтий-Ус ХХК нь гэрээгээр 2016 оны 05 сарын 01-ны өдөр эхэлж 2016 оны 06 сарын 15-ны дотор дуусах ёстой боловч хугацаандаа хийж дуусгаагүй бөгөөд гэрээг дахин сунгаж 2016 оны 10 сарын 15-ны өдөр эхэлж 2016 оны 11 сарын 15-ны дотор дуусгахаар болсон байна.

3.4 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 21.9 сая төгрөгийн ажлууд хийгдээгүй байна.

3.4а 2015 онд 329.5 мянган төгрөгийг байгаль хамгаалах нөхөн сэргээх чиглэлээр аймгийн ИТХ-аар амьтан, тусгай хамгаалалтын газар, уул уурхай нөхөн сэргээлт, усан хангамж, ойн чиглэлээр гэсэн 23 төрлийн 48 ажлууд хийхээр төлөвлөсөн байна.

Чиглэл тус бүрээр хийгдэх ажлуудын санхүүжилт бүрэн олгогдсон боловч дараах ажлууд хийгдээгүй байна.Үүнд:

Улз голын сав дагуух мониторинг судалгааны ажилд суманд хийх 2.0 сая төгрөгийн, Ерөө голын сав газарт хамаарагдах усны тооллого хийх, эрүүл мэндийн бүс тогтоох 0.5 сая төгрөгийн, Мөрөн сумын 10 га газрын ойжуулалтын 6.9 сая төгрөг, Норовлин сумын ойн зурвас 6.0 сая төгрөг, хорт ургамлын судалгаа хийх 4.0 сая төгрөг, усны салбарын уулзалт зөвлөгөөн 2.5 сая төгрөг нийт 21.9 сая төгрөгийн ажлууд хийгдээгүй байна.

2015 оны 06 сарын 12-ны өдрийн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 30 тоот тогтоолоор Мөрөн сумын 10 га талбайд ойжуулалт хийх ажлын хуваарь, зардлыг Цэнхэрмандал сумын навчит модны плантацын дэргэд уст цэг гаргах ажилд 6.9 сая төгрөг болгон өөрчилсөн мөн 11 сарын 06-ны өдрийн 44 тоот тогтоолоор Хэрлэн сумын Хэрлэн голын 5.5 га талбайн эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг ажлын хуваарь зардлыг нэрийг Хэрлэн сумын Хэрлэн голын эрэгт Цөөрөм байгуулах ажлын хашаа худалдан авах зардалд 22.0 сая төгрөг, Хэрлэн сумын нийтийн хог цэвэрлэгээнд зориулан хог тээвэрлэх автомашин 28.3 сая төгрөг, Чингис хотын нийтийн цэвэрлэгээ болон төвлөрсөн цэгийн хогийг дарж булах шатахууны зардалд 1.0 сая төгрөг, Үүлэнд нөлөөлөх ажлын санхүүжилтын зардал 5.5 сая төгрөг гэснийг 1.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж 6.9 сая төгрөг гэж тус тус өөрчилсөн байна.

Хулгайгаар ан хийдэг, эмийн ургамал түүдэг, өнгөт чулуу, жонш олборлодог, загас агнадаг иргэдтэй тэмцэх, ой хээрийн түймэрээс урьдчилан сэргийлэх зардал хүрэлцдэггүй, байгаль

хамгаалагчид нэн түрүүнд байх шаардлагатай мотоцикль, гар утас, бие хамгаалах хэрэгсэл, зургийн аппарат зэрэг техник хэрэгслийн хөрөнгө санхүүгийн асуудлын шийдэж өгөөгүй байхад аймгийн ИТХурлын Тэргүүлэгчид байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаас Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолын 3 дахь заалтыг зөрчиж, Хэнтий-Ус ХХКомпанид 25.7 сая төгрөгөөр хогны машин, хог дарж булах шатахууны зардалд 1.0 сая төгрөг нийт 26.7 сая төгрөгийг зарцуулах шийдвэр гаргасан байна.

Энэ нь БОАЖГ аймгийн ИТХ-д шаардлагатай асуудлыг оновчтой тавьж шийдүүлж чаддаггүйтэй холбоотой байна.

Мөн 2015 онд Хэнтий аймгийн хэмжээнд 11 сумын нутаг дэвсгэрт нийт 26 удаагийн ой хээрийн түймэр гарч үүнээс ойн 4, ой хээрийн 5, хээрийн түймэр 16 удаа гарч тухайн түймэр гарсан нутаг дэвсгэрт ойжуулалт, мод тарих ажлууд шаардлагатай байна.

Хэрлэн голын эрэгт Цөөрөм байгуулах ажлын хашаа худалдан авахад зориулан 19.6 сая төгрөг зарцуулж уг хашааг юунд ашиглах нь тодорхой бус, зураг төсөв байхгүй зэрэг нь тухайн ажил үр дүн муутай ажил болсон байна. Энэ нь Байгаль хамгаалах нөхөн сэргээх ажилд шаардлагатай хөрөнгийг оновчтой байдлаар шийдүүлэх, зохион байгуултын ажил дутагдалтай байгааг харуулж байна.

2015, 2016 оны Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаар хийгдсэн зарим ажлуудыг газар дээр нь тулгахад

- Өмнөдэлгэр сумын төвийн худагт ус цэвэршүүлэх тоног төөрөмж суурилуулсан бөгөөд ус цэвэршүүлэх тоног төхөөрөмж хэвийн ажиллаж усны ёнкос нь худагт багтах зай байхгүйгээс гадаа айлын хашаанд, Баян-Адрага сумын Дуурлиг нарсны баруун хэсэгт Биндэр СДОАнгийн хийсэн ойжуулалт зуны халуун наранд хатсан Аймгийн Комисс ирж намар 10 сард ойжуулалтыг дахин хийхээр болсон, Дадал сумын булгийн эх хаших ажил хашаагаа тойруулж хийсэн ажлын явц 90 хувьтай, Норовлин сумын төвийн худгийн ус цэвэршүүлэх тоног төхөөрөмжийн ёнкос ирээгүй, Цэнхэрмандал сумын Навчит мод үржүүлгийн газрыг өргөтгөх зорилгоор 2 га газарт навчит модны плантаци байгуулж плантацид хайлаас, улиасыг мөчрөөр үржүүлэн тарьсан ба гүний худгийг гаргаж тойруулаад модон хөлтэй тор татан хашаа барьсан байна.
- Галшар сумын Буянтын булгийн эхийг хашиж хамгаалах ажлыг Жаргалтхаан сумын иргэн Э.Тайванжаргал 5.0 сая төгрөгийн өртөгтэй хийж гүйцэтгэсэн байна. Уг булгийн эхийг өмнө нь хашсан төмөр торон хашаа, хашааны хөлийг бат бэх суулгасан ба булгаа тойруулаад нилээн том талбайтай байсан. Сүүлийн шинээр барьсан хашаа нь өмнөх хашааныхаа дотор талд нь сургаагаар барьсан бөгөөд ач холбогдол, чанарын хувьд хангалттай сайн байна.
- Бор-Өндөр суманд 2015 онд 1 булгийн эхийг 4.0 сая төгрөг, 2016 онд 1 булгийн эхийг хашиж хамгаалах 2.5 сая төгрөгийн өртөгтэйгээр хашсаныг газар дээр нь үзэхэд булгийн эхийг төмөр хашаагаар чанартай хийж гүйцэтгэсэн байна. Хашааны хаалга нь нурсан байдалтай байсан.
- 2016 онд Бор-Өндөр сумын Нэгдсэн эмнэлэг, Бүжинхэн цэцэрлэг, Энхжин цэцэрлэгүүдэд 8 литрийн багтаамжтай ус цэвэршүүлэх төхөөрөмж тавьсныг очиж үзэхэд хэвийн ажиллаж байсан.
- Цахирт-Өндөр ХХК-ны гүйцэтгэсэн Дэлгэрхаан сумын Хэрлэн тооно уулыг улсын тусгай хамгаалттай газар нутгийг тэмдэг, тэмдэглэгээ отог байгуулсан ажлын зарим хэсгийг очиж үзэхэд чанартай гүйцэтгэсэн байна.

2015 онд Онон голын сав газрын захиргаанд усны тооллого зохион байгуулах ажилд 16.5 сая төгрөгийг шилжүүлсэн боловч тухайн газар нь ажлаа хийгээгүй байсан тул уг хөрөнгийг шалгуулахаар аймгийн Цагдаагийн газарт хандаж хариу ирээгүй байна.

3.4 б Сумдын байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй

4.1 Сумдын байгаль хамгаалах санд дотоод хяналтын үр дүнтэй тогтолцоо бүрдээгүй байна

4.1 а 2015 оны БОАЖГ-ын байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаар хийсэн ажил, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого бүрэн бүрдэж байгаа эсэх, төсөл хөтөлбөр үр дүнтэй хэрэгжсэн эсэхэд дотоод хяналтын тогтолцоо бүрдсэн байна.

4.1б.Цэнхэрмандал сумын байгаль хамгаалах сангийн хөрөнгөөс тээвэр шатахууны зардалд зарцуулсан 5.4 сая төгрөгийн шатахуун зарцуулалтын тайланг гаргаагүй, байгаль хамгаалагчид олгосон 0.2 сая төгрөгийн принтерийн хорны үнийг няравын материалын тайлангаар орлого аваагүй шууд зарлагдсан, Өмнөдэлгэр сумын байгаль хамгаалах сангаас зарцуулсан шатахууны зөвшөөрлийг ЗДТГазрын дарга өгсөн байна.

Биндэр сумын байгаль хамгаалах сангаас 0.4 сая төгрөгөөр автомашины сэлбэг худалдан авсан зэрэг нийт 6.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Хэрлэн сум зөвшөөрөлгүйгээр Хаан банкинд нөхөн сэргээлтийн хөрөнгө төвлөрөх нэртэй данс нээж 2015 оны эхний үлдэгдэл 1.9 сая төгрөг 2015, 2016 онд нөхөн сэргээлтийн барьцаанд нийт 4.4 сая төгрөг төвлөрсөнөөс Хэрлэн сумын Хутаг уулын хойд талд нөхөн сэргээх ажил, хогийн цэгт хог булж дарах ажлын шатахууны зардалд нийт 2.7 сая төгрөгийг зарцуулж 10 сарын 05-ны өдрийн байдлаар 3.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Баян-Адрага сум нь 2016 оны эхний хагас жилд байгаль хамгаалах сангийн дансыг хааснаас хойш орсон жоншны гарал үүслийн 0.5 сая төгрөгийн орлогыг орон нутгийн орлогод төвлөрүүлээгүй бэлнээр байлгаж байсан нь Сангийн сайдын 2012 оны Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын 2.6 дахь заалтыг зөрчсөн байна.

Норовлин сум нь 6.2 сая төгрөг, Дэлгэрхаан сум нь 6.4 сая төгрөг, Биндэр сум нь 6.0 сая төгрөг, Баян-Адрага, Жаргалтхаан сумд нь 0.5 сая төгрөг нийт 19.2 сая төгрөгт албан шаардлага хүргүүлж, Хэрлэн сум нь 3.6 сая төгрөгийн, Баян-Адрага сум нь 0.5 сая төгрөгийн нийт 4.1 сая төгрөгт төлбөрийн акт тогтоож, Цэнхэрмандал сум нь 5.6 сая төгрөгийн, Биндэр сум нь 0.4 сая төгрөгийн нийт 6.0 сая төгрөгийн зөрчилд аудитын зөвлөмж өгч ажиллалаа.

Үүнээс үзэхэд байгаль хамгаалах сангийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй байгааг харуулж байна.

4.2 Сумын байгаль хамгаалах сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна.

4.2а Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээгээр хийгдсэн ажлуудыг ажил тус бүрийг хариуцсан мэргэжилтэн байлцан комисс томилж хүлээн авдаг байна.

4.2б Байгаль хамгаалах сангийн 2015, 2016 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд аудит хийхэд хайгуулийн лицензтэй компани нөхөн сэргээх барьцааны орлого, торгуулийн орлогоос өөр төрлийн орлого байхгүй, тухайн жилд баталсан зардлын төлөвлөгөө хөтөлбөр байхгүй, санхүү хяналт дотоод аудитын алба сүүлийн 2 жил дараалан санхүүгийн хяналт шалгалт хийгдээгүй, зардлын нилээд хувийг шатахууны зардалд зарцуулж өөр төрлийн зардалд зарцуулах зардал хүрдэггүй зэргээс үзэхэд санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй байна.

4.3 Байгаль хамгаалах сангийн мэдээллийг шилэн дансанд мэдээлээгүй байна.

4.3а Аймгийн БОАЖГ нь байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 5.0 сая төгрөгийн үнийн дүнгээс дээш гүйлгээг шилэн дансны цахим хуудасанд шивж байршуулан Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.

4.36 Сумдын байгаль хамгаалах санд 5.0 сая төгрөгийн үнийн дүнгээс дээш төгрөгийн гүйлгээ гараагүй ба байгаль хамгаалах сангаас хөрөнгө зарцуулсан тогтоол шийдвэрүүдийг Шилэн дансны цахим хуудасанд байршуулаагүй байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

- Сумдын байгаль хамгаалах сангийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин бүрдээгүй байна.
- Сумын орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлэх 19.2 сая төгрөгийн орлогыг сумын байгаль хамгаалах санд төвлөрүүлж зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн байна.
- Аймгийн ИТХ-аар байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг батлахдаа “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай” хуулийн 18.1-д тогтоосон хувь хэмжээг баримтлахгүй байна.
- Аймгийн ИТХ байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах зардлаас 26.7 сая төгрөгийг Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан журмын 3.2, 3.3, 3.4 дахь заалтыг зөрчин шийдвэр гаргасан байна.

Аймгийн ИТХ-ын дарга Л.Батсайхан-д:

- Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай” хуулийн 18.1-д тогтоосон хувь хэмжээг баримтлан батлах

Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга С.Хэрлэнчимэг-т

- 2016 оны Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль хамгаалах нөхөн сэргээх зардалд зарцуулах зардлыг хуулийн дагуу тооцож олгож байх
- Сумдын байгаль хамгаалах сангийн үйл ажиллагааг зогсоож, дансанд байгаа нөхөн сэргээлтийн барьцаа мөнгийг БОНХС-ын 2014 оны А/04 тушаалаар батлагдсан “Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам” –ын 1.3-т заасан сумын нөхөн сэргээлтийн тусгай дансанд байршуулах

Аймгийн БОАЖГ-ын дарга Г.Энхбаяр-т

- Сумдын байгаль хамгаалагч нарын шаардлагатай техник хэрэгслэлээр хангуулах талаар үе шаттайгаар холбогдох газарт нь асуудлыг тавьж ажиллах
- Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлаар хийгдэх ажлын гүйцэтгэлд тавих дотоод хяналтыг сайжруулах, зардлыг үр дүнтэй зарцуулах

Тайлан бичсэн: Аудитор

Ү.Төгсжаргал

2016 оны 09 дугаар сарын 29

